



## Баримт #1 Та КОВИД-19 вирусын вакцинаас КОВИД-19 вирус тусахгүй.

КОВИД-19 вирусын вакцин вирусын ямар ч хэсгийг агуулаагүй тул уг вакцинаас болж та КОВИД-19 вирус тусахгүй. КОВИД-19 вирусын вакцин таныг вирусээс хамгаална. Вакцин хийлгэсний дараа тань гарын булчин хөндүүрлэх эсвэл халуурах зэрэг сөрөг нөлөө ажиглагдаж болно. Эдгээр нь хэвийн бөгөөд нийтлэг тохиолддог зүйлс юм.



## Баримт #2 КОВИД-19 вирусын вакцин нь маш түргэн бүтээгдсэн хэдий ч хэрэглэхэд аюулгүй юм.

КОВИД-19 вирусын вакциныг бүтээхэд шаардлагатай алхмуудыг алгасаагүй. Дэлхий даяарх эрдэмтэд энэ технологи дээр арав гаруй жилийн турш ажиллаж байна. Тийм ч учраас аюулгүй бөгөөд үр дүнтэй вакциныг маш хурдан гаргаж авч чадсан билээ.



## Баримт #3 КОВИД-19 вирусын вакцин таныг вирусын нэгээс олон төрлөөс хамгаалж чадна.

Вирусүүд цаг хугацааны явцад өөрчлөгдөж эсвэл бага хэмжээгээр хувьсал буюу мутацид ордог. Мэдээллээс харахад КОВИД-19 вирусын вакцинууд нь өнөөг хүртэл бидний илрүүлээд байгаа КОВИД-19 өвчнийг үүсгэдэг вирусын төрлийн эсрэг идэвхтэй нөлөөтэй байна.



## Баримт #4 КОВИД-19 вирусын вакцин таны ДНХ-г өөрчлөхгүй.

КОВИД-19 вирусын вакцин нь mRNA вакцин бөгөөд таны ДНХ-д ямар нэг байдлаар нөлөөлөхгүй. Тус вакцинууд нь таныг КОВИД-19 вирусын халдвар авахаас хамгаалдаг эсрэг биетүүдийг үүсгэдэг дархлааны хариу урвалыг өдөөдөг.



## Баримт #5 КОВИД-19 вирусын вакцинууд нь үргүйдэл эсвэл үр зулбалттай хамааралгүй байна.

КОВИД-19 нь тус вирусээр өвчилсөн эмэгтэйчүүдэд үргүйдэл үүсгээгүй тул вакциныг үргүйдэл үүсгэнэ гэж бодох шаардлагагүй юм. Онлайнар тархсан нэгэн **худал** мэдээлэл байгаа нь; вакцин дахь уураг эхэс дэхь уургийг гэмтээдэг гэсэн мэдээлэл юм. **Энэ бол үнэн биш.** Хоёр уураг дахь бага хэмжээний амин хүчил ийм нөлөө үзүүлэхгүй. КОВИД-19 вирусын вакцинуудыг жирэмсэн эмэгтэйчүүд дээр туршаагүй боловч жирэмсэн эмэгтэйчүүд жирэмсэн байх үедээ өөр бусад өвчнүүдийн улмаас вакцин хийлгэдэг. Жирэмсэн эмэгтэйчүүд КОВИД-19 вирусын улмаас ноцтой өвчлөх өндөр эрсдэлтэй бөгөөд та хүүхдээ төрүүлсний дараа хүүхдэдээ КОВИД-19 халдах эрсдэл байж болно. Вакцинжуулалтад хамрагдах ёстой эсэх талаар эмчтэйгээ ярилцаж үзээрэй.



## Баримт #6 КОВИД-19 вирусын вакцинууд микрочип эсвэл хянах төхөөрөмж агуулаагүй болно.

КОВИД-19 вирусын вакцинууд микрочип эсвэл хянах төхөөрөмж агуулдаг гэсэн ташаа мэдээлэл **худал болох нь батлагдсан**. Бид вакцин бүр юу агуулж буйг нарийн тодорхой мэднэ. Вакцин бүр дэх найрлагын жагсаалтыг [онлайн](#)архарах боломжтой.



## Баримт #7 Архаг суурь өвчин эсвэл эмгэгтэй хүмүүс вакцин хийлгэх ээлж нь болмогц аль болох хурдан вакцинжуулалтад хамрагдах нь зүйтэй.

Хэрэв та чихрийн шижин зэрэг архаг өвчтэй бол КОВИД-19-ийн улмаас ноцтой өвчлөх өндөр эрсдэлтэй байна. КОВИД-19 вирусын вакцинууд нь архаг суурь өвчин эсвэл эмгэгтэй хүмүүст аюулгүй бөгөөд үр дүнтэй.